



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/460

Булган сум

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн технологит ажлын хүрээнд хийгдэж буй мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг малчин өрх тус бүрээр үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах ажил аймгийн хэмжээнд удаашралтай байгаа тул сумын Засаг даргын Тамгын газрын Малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Булган суманд зохион байгуулсугай.

2. Сургалтыг зохион байгуулж, аймгийн дүн мэдээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулж дуусгахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.

3. Дээрх сургалтын зардлыг хавсралтаар баталж, шаардагдах 900,000 (есөн зуун мянга) төгрөгийг “Бэлчээрийн менежмент” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010595

Аймгийн Засаг даргын 2024 оны
06 дүгээр сарын 21 -ний өдрийн А/460
дугаар захирамжийн хавсралт



МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН
САНГИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Сургагч багшийн зардал	2 хоног	300,000	300,000
2	Нэгдсэн санд мэдээлэл оруулах заавар	20 ширхэг	10,000	200,000
3	Цайны завсарлага	20 хүн*2 хоног	10,000	400,000
	Бүгд			900,000